

**AND ENERGY**

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН МАТЕРИАЛ**



**2022 оны 4 сарын 23**

**ОРХОН АЙМАГ**

### Хурлын тов:

2022 оны 4 сарын 23-ны өдрийн 14:00 цагт

### Хурал болох газар:

Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян зам 3-4,6 тоот Анд-Энерги компанийн байр /цахим хэлбэрээр/ And Energy фэйсбүүк хаягаас

### Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэх өдөр:

2022 оны 4 сарын 4-ний өдрийн 17:00 цаг

### Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
2. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай;
3. Компанийн ногдол ашиг хуваарилах эсэх талаар ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах.



## АГУУЛГА

1. Компанийн танилцуулга
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай ТУЗ-ийн тогтоол
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар, танилцуулах баримт бичгийн жагсаалт
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоол
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудас
7. 2021 онд хийгдсэн ажлууд
8. Онцлох үйл явдлууд
9. Санхүүгийн үзүүлэлтүүд
10. Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчийн танилцуулга
11. 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө
12. Хараат бус аудит дүгнэлт



## КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

КОМПАНИЙН  
ОНООСОН НЭР

Анд-Энерги ХК

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ЧИГЛЭЛ

- LED гэрэл, гэрэлтүүлгийн үйлдвэрлэл
- Цахилгаан тоног төхөөрөмжийн угсралт, засвар үйлчилгээ
- Үйлдвэрлэлийн автоматжуулалт
- Гадаад худалдаа

АЛБАН ЁСНЫ ХАЯГ

Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Уртын гол баг, Баян-Зам 3-4,6 тоот  
Утас: 77711010  
И-мэйл: info.andenergy@gmail.com  
Вэб сайт: www.andenergy.mn  
Фейсбүүк: And energy

КОМПАНИЙН  
УДИРДЛАГА

ТУЗ-н дарга: Далхаагийн Мөнхбаяр  
Гүйцэтгэх захирал: Цэнд-Аюушийн Гүррагчаа

ҮҮСГЭН  
БАЙГУУЛАГДСАН  
ОГНОО

2011 оны 5-р сарын 23 өдөр

АЖИЛЧДЫН ТОО

36

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН  
ХҮЧИН ЧАДАЛ

Өдөрт 500-800 гэрэл үйлдвэрлэх

## “АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 3 сарын 12 өдөр

Дугаар 22/06

Орхон аймаг

### *Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр хуралдуулах тухай*

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх заалтууд, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоол, “Анд-Энерги” ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, 10.3, 10.9 дахь заалтыг тус тус үндэслэн “Анд-Энерги” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. “Анд Энерги” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 4 сарын 23-ны өдрийн 14:00 цагт Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян зам 3-4,6 тоотод байрлах өөрийн байранд цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж байгаатай холбогдуулан **MI SURVEY** программыг цахим бүртгэл, санал хураалт явуулахад ашиглахыг зөвшөөрсүгэй.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
  - 3.1 Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
  - 3.2 Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай;
  - 3.3 Компанийн ногдол ашиг хуваарилах эсэх талаар ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 4 сарын 4-ны өдрийн 17:00 цаг байхаар тогтсугай.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хүргэх хурлын зарын агуулгыг Хавсралт №1-ээр баталж, 2022 оны 3 сарын 17-нд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, Компанийн болон Биржийн цахим хуудсаар дамжуулан мэдээлж, зарыг давтан 2022 оны 4 сарын 1-ний өдөр анх мэдээлсний дагуу нийтэд дахин мэдээлэхийг зохион байгуулах комисст даалгасугай.
6. Танилцах баримт бичгийн жагсаалт, Ээлжит хурлын дэгийг Хавсралт №2-оор баталж, 2022 оны 3 сарын 22-ны өдөрт багтаан хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, диллерийн компаниудад цахим хэлбэрээр хүргүүлж, тухайн өдрөөс эхлэн 09:00-17:00 цагийн хооронд Анд-Энерги ХК-ийн үйлдвэрийн байранд ирж танилцах болон

[www.andenergy.mn](http://www.andenergy.mn) цахим хуудсаар орж хурлын материалыг электрон хэлбэрээр татан авч танилцах боломжийг бүрдүүлсүгэй.

7. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг Хавсралт №3, Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тогтоолын төслийг Хавсралт №4, Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тогтоолын төслийг Хавсралт №5, ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай тогтоолын төслийг Хавсралт №6-аар тус тус баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчдээс хурлын санал хураалтыг <https://hural.andenergy.mn> веб хаягаар 2022 оны 4 сарын 23-ны өдрийн 15:30 цаг хүртэл урьдчилан болон Хурлын үеэр тус тус цахимаар хүлээн авна.
9. Хувьцаа эзэмшигчийн хурлын мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-н нэгдүгээр хавсралтаар батлагдсан загварын дагуу гаргаж холбогдох баримтын хамт 2022 оны 3 сарын 15-ны өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах хороо болон Монголын Үнэт Цаасны Бирж ХК-д тус тус хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Тогос-Эрдэнэд даалгасугай.
10. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг шинээр сонгохтой холбогдуулан Монголын Үнэт Цаасны Бирж ХК болон [www.andenergy.mn](http://www.andenergy.mn) цахим хуудсаар дамжуулан сонгон шалгаруулалтын зар байршуулахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Тогос-Эрдэнэ, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн Д.Алтангэрэл нарт тус тус даалгасугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Мөнхбаяр, Хурал зохион байгуулах комиссын даргаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Тогос-Эрдэнэ, гишүүдээр ТУЗ-ийн гишүүн Т.Барс, М.Ганбат, Гүйцэтгэх захирал Ц.Гүррагчаа, Маркетингийн менежер М.Дэлгэрмаа, Тооллогын комиссын даргаар тооцооны нягтлан бодогч Д.Ундармаа, гишүүдээр Бичиг хэргийн ажилтан А.Байгальмаа, Үйлдвэрлэлийн менежер А.Алтансүх нарыг тус тус томилсугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж, холбогдох дүрэм журамд нийцүүлэн ажиллахыг Хурлын дарга Д.Мөнхбаяр, Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Тогос-Эрдэнэ нарт тус тус үүрэг болгосугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зохион байгуулалттай холбоотой зардлыг компаниас гаргаж, тус тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг өөртөө үлдээсүгэй.

ТУЗ-ИЙН ДАРГА



Д.МӨНХБАЯР

“Анд-Энерги” ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 3 сарын 12-ны  
өдрийн 22/06 тоот тогтоолын Хавсралт №1

## АНД ЭНЕРГИ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Анд Энерги ХК нь ТУЗ-ийн 2022 оны 3 сарын 12-ны өдрийн 22/07 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал цахим хэлбэрээр хуралдах болсныг зарлаж байна.

**Компанийн оноосон нэр:** Анд-Энерги ХК

**Хурал хуралдуулах өдөр, цаг:** 2022 оны 4 сарын 23-ны өдрийн 14:00 цагт [www.facebook.com/AndEnergy](http://www.facebook.com/AndEnergy) цахим хуудсаар хуралдана.

### ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
2. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай;
3. Компанийн ногдол ашиг хуваарилах эсэх талаар ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах.

### БҮРТГЭЛИЙН ӨДӨР: 2022 оны 4 сарын 4-ны өдөр

Хувьцаа эзэмшигч та 2022 оны 3 сарын 22-ны өдрөөс 2022 оны 4 сарын 22-ны өдөр хүртэл ажлын өдрүүдэд 9:00-17:00 цагийн хооронд Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян зам 3-4,6 тоот ажлын байранд хүрэлцэн ирэх эсвэл компанийн [Andenergy.mn](http://Andenergy.mn) болон өөрийн харилцдаг брокер диллерийн цахим хуудсаар хурлын материалтай танилцах боломжтой.

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ ХУРЛЫН БАРИМТ БИЧГҮҮД:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлт;
3. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудасны загвар;
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл
6. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга.

### САНАЛЫН ХУУДАС ХҮЛЭЭН АВАХ СҮҮЛИЙН ХУГАЦАА:

Хувьцаа эзэмшигчдээс хурлын санал хураалтыг <https://hural.andenergy.mn> веб хаягаар 2022 оны 04 сарын 23-ний өдрийн 15:30 цаг хүртэл урьдчилан цахимаар болон Хурлын үеэр цахимаар тус тус хүлээн авна.

Хаяг: Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян зам 3-4,6 тоот

Утас: 99351516, 99363623, 77711010

Имэйл хаяг: [erdenetledandenergy@gmail.com](mailto:erdenetledandenergy@gmail.com)

### ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

“Анд-Энерги” ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 3 сарын 12-ны  
өдрийн 22/06 тоот тогтоолын Хавсралт №2

**АНД-ЭНЕРГИ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ  
ХОЛБООТОЙ МАТЕРИАЛ**

№	Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл	Бэлэн болох хугацаа
1	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол	2022.03.14
2	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдэл	2022.03.14
3	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар	2022.03.14
4	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг	2022.03.14
5	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл	2022.03.14
6	Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудасны загвар	2022.03.14
7	Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан	2022.03.14
8	Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн ТУЗ-ийн гаргасан дүгнэлт	2022.03.18
9	Компанийн ТУЗ-д нэр дэвшигчдийн танилцуулга	2022.03.18
10	Компанийн ногдол ашиг хуваарилах эсэх талаар ТУЗ-ийн шийдвэр тогтоол	2022.02.16

**АНД-ЭНЕРГИ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

**Хурал хуралдах огноо:** 2022 оны 4 сарын 23-ны өдрийн 14:00 цагт

**Хурлын үргэлжлэх хугацаа:** 1 цаг 55 минут

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцах эзэн
1	Хурлын ирцийг бүртгэх	10 минут	Зохион байгуулах комисс
2	Хурлын ирцийг мэдээлэх	5 минут	Тооллогын комисс
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлын дэг болон хэлэлцэх асуудлуудыг танилцуулах	10 минут	Хурлын дарга Д.Мөнхбаяр
4	Компанийн 2021 оны үйл ажиллагааны товч тайланг танилцуулах	15 минут	Гүйцэтгэх захирал Ц.Гүррагчаа
5	Компанийн 2021 оны үйл ажиллагаанд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулах	5 минут	ТУЗ-ийн дарга Д.Мөнхбаяр
6	Компанийн 2021 оны санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулах	5 минут	ТУЗ-ийн дарга Д.Мөнхбаяр
7	Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн тогтоол шийдвэрийг танилцуулах	5 минут	ТУЗ-ийн дарга Д.Мөнхбаяр
8	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга	15 минут	Нэр дэвшүүлэх хороо
9	Асуулт хариулт	15 минут	Зохион байгуулах комисс
10	Хурлын завсарлага, санал тоолох	15 минут	Тооллогын комисс, Зохион байгуулах комисс
11	Санал хураалтын дүнг хуралд оролцогчдод танилцуулах /ХЭХурлын тогтоол/	10 минут	Тооллогын комисс, Хурлын дарга Д.Мөнхбаяр
12	Хурлыг хаах	5 минут	Хурлын дарга Д.Мөнхбаяр

**Жич:** Шаардлагатай бол хурлын хугацааг сунгаж болно.

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

“Анд-Энерги” ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 3 сарын 12-ны  
өдрийн 22/06 тоот тогтоолын Хавсралт №3

## АНД-ЭНЕРГИ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: ..... *овогтой* .....

Регистрийн дугаар: .....

Хувьцаа эзэмшигчдийн хурал: *Ээлжит*

Санал өгөх хувьцааны тоо .....

Үнэт цаасны компанийн нэр: .....

*Анд-Энерги ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 23-ний өдрийн 14:00 цагт Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян зам 3-4,6 тоотод байрлах “Анд-Энерги” ХК-ийн өөрийн байранд*

№	Хэлэлцэх асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах			
2	Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах			

### Санал өгсөн түүх

IP хаяг	Хөтөч	Хост	Огноо
1			

2022 оны 4 сарын 23-ны өдөр



“Анд-Энерги” ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 3 сарын 12-ны  
өдрийн 22/06 тоот тогтоолын Хавсралт №4

[Төсөл]

## “АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 4 сарын 23 өдөр

Дугаар 01

Орхон аймаг

*Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн  
Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 2022 оны 4 сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анд-Энерги ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны тайланг дүгнэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Д.МӨНХБАЯР

“Анд-Энерги” ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 3 сарын 12-ны  
өдрийн 22/06 тоот тогтоолын Хавсралт №5

[Төсөл]

## “АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 4 сарын 23 өдөр

Дугаар 02

Орхон аймаг

*Компанийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн  
Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 2022 оны 4 сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анд-Энерги ХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн Хараат бус аудитын тайлан дүгнэлтийг Хангалттай үнэлгээгээр баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Д.МӨНХБАЯР

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын нэгдүгээр Хавсралт

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	АНД-ЭНЕРГИ ХК
Хаяг:	Хаяг: Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян зам 3-4,6 тоот Утас: 77711010
Хурал хуралдах өдөр, цаг:	2022 оны 4 сарын 23-ны өдөр, 14:00 цаг
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян Зам 3-4,6 тоотод байрлах “Анд-Энерги” ХК-ийн өөрийн байр <a href="http://www.facebook.com/AndEnergy">www.facebook.com/AndEnergy</a>
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн Удирдах Зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2022 оны 3 сарын 12
Олон нийтэд зарлах огноо:	2022 оны 3 сарын 17 2022 оны 4 сарын 1
Бүртгэлийн өдөр:	2022 оны 4 сарын 4
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер, диллерийн компанид хүргүүлэх огноо:	2022 оны 3 сарын 22
Хүргүүлсэн огноо:	2022 оны 3 сарын 15
Хурлын даргын нэр:	Далхаа овогтой Мөнхбаяр
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Тооллогын комиссын дарга: Д.Ундармаа, Тооллогын комиссын гишүүн: А.Байгальмаа, А.Алтансүх
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	Хавсралтаар
Баримт, бичгийн хуудасны тоо:	.... ширхэг
	.... хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

..... /Б.ТОГОС-ЭРДЭНЭ/

2022 оны 3 сарын 12-ны өдөр

Дээрх мэдээллийг, хавсралт материалын хамт 2 хувь үйлдэж Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад тус тус хүргүүлнэ.

## “АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 22/04

Орхон аймаг

### *Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүгнэлт өгөх тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 81 дүгээр зүйлийн 81.3 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2.6.12 дахь заалт, 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Анд-Энерги” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг “Хангалттай” хэмээн дүгнэсүгэй.
2. “Анд-Энерги” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг өөртөө үлдээсүгэй.

ТУЗ-ИЙН ДАРГА



Д.МӨНХБАЯР

## “АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 22/02

Орхон аймаг

### *Ногдол ашиг хуваарилах эсэх тухай*

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5, 46.6 дахь заалт, “Анд-Энерги” ХК-ийн ногдол ашигийн бодлого, ногдол ашиг хуваарилах журмын 2 дугаар зүйлийн 2.7 дахь заалт, 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Анд-Энерги” ХК-ийн 2021 оны үйл ажиллагаанаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн энэхүү тогтоолын үндэслэлийг 2022 оны 04 дүгээр сард болох Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахаар тогтсугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Д.МӨНХБАЯР

“Анд-Энерги” ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 3 сарын 12-ны өдрийн 22/06 тоот тогтоолын Хавсралт №3

**АНД-ЭНЕРГИ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН  
ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: ..... *овогтой* .....

Регистрийн дугаар: .....

Хувьцаа эзэмшигчдийн хурал: *Ээлжит*

Санал өгөх хувьцааны тоо .....

Үнэт цаасны компанийн нэр: .....

Кумулятив саналын тоо: .....

*Анд-Энерги ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 23-ний өдрийн 14:00 цагт Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян зам 3-4,6 тоотод байрлах “Анд-Энерги” ХК-ийн өөрийн байранд*

№	ТУЗ-д нэр дэвшигчдийн нэрс	
	<i>Ердийн гишүүд</i>	Таны ердийн гишүүнд өгөх кумулятив саналын тоо: .....
1		
2		
3		
...		
...		
...		
	<i>Хараат бус гишүүд</i>	Таны хараат бус гишүүнд өгөх кумулятив саналын тоо: .....
1		
2		
...		
...		
<b>Өгөх ёстой кумулятив саналын тооны нийлбэр дүн: .....</b>		

**Санамж:** ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй (100\*9 гишүүн=900) болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн энгийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу.

**Санал өгсөн түүх**

IP хаяг	Хөтөч	Хост	Огноо
1			

2022 оны 4 сарын 23-ны өдөр

## АНД-ЭНЕРГИ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ



**Нэг. Ерөнхий мэдээлэл**

*Эцэг/эх/-ийн нэр:* Далхаа

*Өөрийн нэр:* Мөнхбаяр

*Төрсөн огноо:* 1976/10/26

*Боловсрол:* Дээд

*Мэргэжил:* Механик инженер

*Одоо эрхэлж байгаа албан тушаал:*

“Анд-Энерги” ХК-ийн ТУЗ-ийн дарга

**Хоёр. Боловсрол:**

Их, дээд сургууль болон мэргэжил дээшлүүлэх сургалт, курс

Хаана	Сургуулийн нэр	Он		Эзэмшсэн мэргэжил	Зэрэг цол
		Элссэн	Төгссөн		
Орхон аймаг	5-р сургууль	1984	1994	Бүрэн дунд боловсрол	
Орхон аймаг	Ш.Отгонбилэгийн нэрэмжит ТС	2010	2014	Механик инженер	Бакалавр

**Гурав. Ажлын туршлага:**

Байгууллагын нэр	Албан тушаал	Огноо	
		Орсон	Гарсан
Эрдэнэт Үйлдвэр ХХК	Цахилгаанчин	2004	2017
“Анд-Энерги” ХК	Маркетинг, борлуулалтын хэлтсийн дарга	2017	2019
“Анд-Энерги” ХК	Үйлдвэрийн мастер	2019	2020
“Анд-Энерги” ХК	ТУЗ-ийн дарга	2020	

## АНД-ЭНЕРГИ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ



**Нэг. Ерөнхий мэдээлэл**

*Эцэг/эх/-ийн нэр:* Цэнд-Аюуш

*Өөрийн нэр:* Гүррагчаа

*Төрсөн огноо:* 1981/03/11

*Боловсрол:* Дээд

*Мэргэжил:* Ил уурхайн цахилгаан,  
механик тоног төхөөрөмжийн инженер

*Одоо эрхэлж байгаа албан тушаал:*

“Анд-Энерги” ХК-ийн Гүйцэтгэх захирал

**Хоёр. Боловсрол:**

Их, дээд сургууль болон мэргэжил дээшлүүлэх сургалт, курс

Хаана	Сургуулийн нэр	Он		Эзэмшсэн мэргэжил	Зэрэг цол
		Элссэн	Төгссөн		
Архангай, Өндөр-Улаан	Архангай, Өндөр-Улаан 10 жил	1987	1995	Бүрэн бус дунд боловсрол	
Улаанбаатар	28-р сургууль	1995	1997	Бүрэн дунд боловсрол	
Улаанбаатар	ШУТИС	1997	2001	УЦМ инженер	Бакалавр
Улаанбаатар	ШУТИС		2010	УЦМ инженер	Магистр
Улаанбаатар	ШУТИС		2022	УЦМ инженер	Мэргэшсэн инженер

**Гурав. Ажлын туршлага:**

Байгууллагын нэр	Албан тушаал	Огноо	
		Орсон	Гарсан
“Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ	Цахилгаанчин	2002	2007
“Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ	Инженер	2007	2016
“Анд-Энерги” ХК	Гүйцэтгэх захирал	2016	

## АНД-ЭНЕРГИ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ



**Нэг. Ерөнхий мэдээлэл**

*Эцэг/эх/-ийн нэр:* Төмөрбат

*Өөрийн нэр:* Барс

*Төрсөн огноо:* 1979/11/28

*Боловсрол:* Дээд

*Мэргэжил:* Ил уурхайн цахилгаан, механик тоног төхөөрөмжийн инженер

*Одоо эрхэлж байгаа албан тушаал:*

Анд-Энерги ХК-ийн Ерөнхий инженер

**Хоёр. Боловсрол**

Их, дээд сургууль болон мэргэжил дээшлүүлэх сургалт, курс

Хаана	Сургуулийн нэр	Он		Эзэмшсэн мэргэжил	Зэрэг цол
		Элссэн	Төгссөн		
Шарын гол	2-р сургууль	1986	1995	Бүрэн дунд боловсрол	
Улаанбаатар	ШУТИС	1997	2001	Уул уурхайн цахилгаан механик инженер	Бакалавр
Улаанбаатар	ШУТИС	2014	2017	Уул уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалтын инженер	Магистр

**Гурав. Ажлын туршлага**

Байгууллагын нэр	Албан тушаал	Огноо	
		Орсон	Гарсан
“Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ	Цахилгаанчин	2001	2003
“Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ	Инженер	2003	2018
“Анд- Энерги” ХК	Захирал, ТУЗ-н дарга, Ерөнхий инженер	2011	2022



## АНД-ЭНЕРГИ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ



**Нэг. Ерөнхий мэдээлэл**

*Эцэг/эх/-ийн нэр:* Ганхуяг

*Өөрийн нэр:* Түвшин

*Төрсөн огноо:* 1983/12/07

*Боловсрол:* Дээд

*Мэргэжил:* Электроникийн инженер

*Одоо эрхэлж байгаа албан тушаал:*

“Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-т Автоматикийн инженер

**Хоёр. Боловсрол**

Их, дээд сургууль болон мэргэжил дээшлүүлэх сургалт, курс

Хаана	Сургуулийн нэр	Он		Эзэмшсэн мэргэжил	Зэрэг цол
		Элссэн	Төгссөн		
Орхон аймаг	1-р сургууль	1991	2001	Бүрэн дунд боловсрол	
Улаанбаатар	МУИС-МТС	2001	2005	Электроникийн инженер	Бакалавр
Улаанбаатар	МГТИС	2021		Уул уурхайн инженер	Магистрантур

**Гурав. Ажлын туршлага**

Байгууллагын нэр	Албан тушаал	Огноо	
		Орсон	Гарсан
“Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ	Цахилгаанчин	2005	2011
“Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ	Автоматикийн инженер	2011	

## АНД-ЭНЕРГИ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ



**Нэг. Ерөнхий мэдээлэл**

*Эцэг/эх/-ийн нэр:* Дагвапунцаг

*Өөрийн нэр:* Алтангэрэл

*Төрсөн огноо:* 1970/06/06

*Боловсрол:* Дээд

*Мэргэжил:* Уул уурхайн цахилгаан механикч

*Одоо эрхэлж байгаа албан тушаал:* АЦХ ХХК-ийн Гүйцэтгэх захирал

**Хоёр. Боловсрол:**

Их, дээд сургууль болон мэргэжил дээшлүүлэх сургалт, курс

Хаана	Сургуулийн нэр	Он		Эзэмшсэн мэргэжил	Зэрэг цол
		Элссэн	Төгссөн		
Улаанбаатар	12-р сургууль	1978	1988	Бүрэн дунд боловсрол	
Улаанбаатар	ТИС	1988	1993	Уул уурхайн цахилгаан механикч	Магистр

**Гурав. Ажлын туршлага:**

Байгууллагын нэр	Албан тушаал	Огноо	
		Орсон	Гарсан
“Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ	Инженер	1993	2002
АЦХ ХХК	Гүйцэтгэх захирал	2005	

## АНД-ЭНЕРГИ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ



**Нэг. Ерөнхий мэдээлэл**

*Эцэг/эх/-ийн нэр:* Эрдэнэбаяр

*Өөрийн нэр:* Мягмардорж

*Төрсөн огноо:* 1964/04/10

*Боловсрол:* Дээд

*Мэргэжил:* Эрх зүйч

*Одоо эрхэлж байгаа албан тушаал:* Өмгөөлөгч

**Хоёр. Боловсрол:**

Их, дээд сургууль болон мэргэжил дээшлүүлэх сургалт, курс

Хаана	Сургуулийн нэр	Он		Эзэмшсэн мэргэжил	Зэрэг цол
		Элссэн	Төгссөн		
Дархан Уул аймаг	10 жилийн 3-р сургууль	1972	1982	Бүрэн дунд боловсрол	
Улаанбаатар	МУИС	1982	1984	Эрх зүйч	
Улаанбаатар	Удирдлагын акедеми	2005	2007	Төрийн удирдлагын менежер	
Улаанбаатар	МУИС		2000	Хууль зүйн ухаан	Магистр
Улаанбаатар	Удирдлагын академи	2010	2012	Удирдахуйн ухаан	Магистр

**Гурав. Ажлын туршлага:**

Байгууллагын нэр	Албан тушаал	Огноо	
		Орсон	Гарсан
Завхан аймгийн АДХГЗ	Хуулийн зөвлөх, арбитрч	1988	1990
Завхан аймгийн шүүх	Шүүгч, аймгийн шүүхийн гишүүн	1990	1995
Оюуны өмчийн газар	Зөвлөх, хэлтэс газрын дарга	1996	2018

## АНД-ЭНЕРГИ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ



**Нэг. Ерөнхий мэдээлэл**

*Эцэг/эх/-ийн нэр:* Мөнхжаргал

*Өөрийн нэр:* Ганбат

*Төрсөн огноо:* 1982/02/09

*Боловсрол:* Дээд

*Мэргэжил:* Эдийн засагч

*Одоо эрхэлж байгаа албан тушаал:*

Орхон аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга

**Хоёр. Боловсрол:**

Их, дээд сургууль болон мэргэжил дээшлүүлэх сургалт, курс

Хаана	Сургуулийн нэр	Он		Эзэмшсэн мэргэжил	Зэрэг цол
		Элссэн	Төгссөн		
Улаанбаатар	87-р сургууль	1989	1999	Бүрэн дунд	
Орхон аймаг	ОУЭЗБДСургууль	1999	2003	Олон Улсын эдийн засагч	Бакалавр

**Гурав. Ажлын туршлага:**

Байгууллагын нэр	Албан тушаал	Огноо	
		Орсон	Гарсан
Өгөөж ХХК	Маркетингийн менежер	2004	2005
Кредит Монгол ББСБ	Орлогч захирал	2006	2008
Хөгжлийн шийдэл ТББ	Бизнес зөвлөх	2008	2012
Орхон аймаг дахь Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим	Дарга	2012	

## АНД-ЭНЕРГИ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ



**Нэг. Ерөнхий мэдээлэл**

*Эцэг/эх/-ийн нэр:* Дашдаваа

*Өөрийн нэр:* Боргио

*Төрсөн огноо:* 1969/02/22

*Боловсрол:* Дээд

*Мэргэжил:* Эрх зүйч, төрийн удирдлагын менежер

Одоо эрхэлж байгаа албан тушаал:

**Хоёр. Боловсрол:**

Их, дээд сургууль болон мэргэжил дээшлүүлэх сургалт, курс

Хаана	Сургуулийн нэр	Он		Эзэмшсэн мэргэжил	Зэрэг цол
		Элссэн	Төгссөн		
Улаанбаатар	31-р дунд сургууль	1977	1987	Бүрэн дунд	
Улаанбаатар	УБИС	1991	1995	Биеийн тамирын багш	Бакалавр
Улаанбаатар	Удирдлагын академи	2000	2001	Төрийн удирдлагын арга зүйч	Менежер
Улаанбаатар	ИЗИС	2013	2015	Эрх зүйч	Бакалавр
Улаанбаатар	Удирдлагын академи	2001	2002	Төрийн удирдлага	Магистр

**Гурав. Ажлын туршлага:**

Байгууллагын нэр	Албан тушаал	Огноо	
		Орсон	Гарсан
Болор сан ТББ	Гүйцэтгэх захирал	2000	2004
Мичид мэдиа лот ХХК	Борлуулалтын менежер	2004	2006
Си ай эс ХХК	Олон нийтийн ажилтан	2006	2007
Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл	Хянан шалгагч	2010	2012
Уб хотын СБД-ийн ИТХ	Албаны дарга	2012	2017

## АНД-ЭНЕРГИ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ



**Нэг. Ерөнхий мэдээлэл**

*Эцэг/эх/-ийн нэр:* Дүүсүрэн

*Өөрийн нэр:* Мөнхбат

*Төрсөн огноо:* 1983/06/29

*Боловсрол:* Дээд

*Мэргэжил:* Бизнесийн удирдлага

*Одоо эрхэлж байгаа албан тушаал:*

Даян Дэлхийн Ногоон Хөгжлийн Институт олон улсын байгууллагын ногоон хотын асуудал хариуцсан мэргэжилтэн

**Хоёр. Боловсрол:**

Их, дээд сургууль болон мэргэжил дээшлүүлэх сургалт, курс

Хаана	Сургуулийн нэр	Он		Эзэмшсэн мэргэжил	Зэрэг цол
		Элссэн	Төгссөн		
Орхон аймаг	1-р сургууль	1991	2001	Бүрэн дунд	
Япон улс	Осакагийн Япон хэлний сургууль	2004	2005	Япон хэлний 1-р түвшин	Япон хэлний сертификат
Япон улс	Осакагийн аялал жуулчлал, үйлчилгээний коллеж	2005	2007	Зочид буудлын менежмент	Мэргэжлийн сертификат
Япон улс	Осакагийн үйлдвэрлэлийн дээд сургууль	2007	2009	Бизнесийн удирдлага	Бакалавр
Япон улс	Киотогийн их сургууль	2015	2017	Бизнесийн удирдлага	Магистр

**Гурав. Ажлын туршлага:**

Байгууллагын нэр	Албан тушаал	Огноо	
		Орсон	Гарсан
Капитал групп ХХК	Эдийн засагч	2009	2010
Мобиком ХХК	Ахлах мэргэжилтэн	2010	2014
Сангийн яам, Хөгжлийн хөтөч төсөл хэрэгжүүлэх нэгж	Эдийн засагч	2017	2019
Даян дэлхийн ногоон хөгжлийн институт	Ногоон хотын асуудал хариуцсан мэргэжилтэн	2019	

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ГЭРЭЛТҮҮЛГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ: 80 нэр төрлийн 21,914 ширхэг ГЭРЭЛ үйлдвэрлэв.

Дотор гэрэлтүүлэг: 20381



Гадна гэрэлтүүлэг: 1487



Гэрэлтдэг үсгэн хаяг: 196



Гэрэлтүүлгийн шон: 59





**АВТОМАТЖУУЛАЛТЫН АЖИЛ**  
"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ТӨҮГ" -н  
Ус хангамжийн цехийн EBARA  
насоснуудын удирдлага,  
хяналтын системийг шинэчлэх  
ажлыг дуусган хүлээлгэж өгөв.

**ЦАХИЛГААН УГСРАЛТ, СУУРИЛУУЛАЛТЫН АЖИЛ**

Орхон аймгийн Баян-Өндөр сумын  
6-0,4кв-н цахилгаан түгээх сүлжээг  
шинэчлэх, сайжруулах ажлыг  
Ричвелл ХХК -тай хамтран гүйцэтгэв.



Булган аймгийн Бүрэгхангай сумын  
төвийн зам дагуу шинээр 19 ширхэг  
гэрэлтүүлгийн шон суурилуулан,  
хуучин гэрэлтүүлгийг засварлав.

**ГУДАМЖ ТАЛБАЙН ГЭРЭЛТҮҮЛГИЙН АЖИЛ**

НАРАН, СОГООТ багийн гэрэлтүүлгийн  
ажилд 14 ширхэг гэрэлтүүлгийн шон  
суурилуулан улсын комисст хүлээлгэн  
өглөө







”ЭРДМИЙН САН СУРГУУЛЬ”  
–ийн гадна талбайн 5 ширхэг  
гоёлын шонтой гэрэлтүүлгийг  
суурилуулав.

### ДОТОР ГЭРЭЛТҮҮЛГИЙН АЖИЛ

”Орхон молл” худалдаа үйлчилгээний  
төвийн дотор 658 ширхэг гэрэлтүүлгийг  
суурилуулах ажлыг гүйцэтгэв.



Хөдөлмөр зуслангийн монгол гэр доторх гэрэлтүүлгийн ажлыг хийж гүйцэтгэв.



## ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 2 давхрын коридорт 24 ширхэг гэрэлтүүлгийг суурилуулж, эрчим хүчний хэмнэлтийг тооцов.



Төслийн үр дүн

1. Орчны гэрэлтүүлгийн хэмжээ 1.4-1.6 дахин нэмэгдсэн.
2. Гэрэлтүүлгийн чадал 1.8 дахин буурсан.
3. Гэрэлтүүлэг сольсон хэсэгт 1 жилд 1,658.9 кВт цахилгаан эрчим хүчийг хэмнэнэ.
4. Эдийн засгийн хувьд 1 жилд 233,222 төгрөгийг хэмнэнэ.



Ерөнхий боловсролын 5-р сургууль Биологийн кабинетэд 15 ширхэг гэрэлтүүлгийг суурилуулав.

Төслийн үр дүн

1. Орчны гэрэлтүүлгийн хэмжээ 2.2-3 дахин нэмэгдсэн.
2. Гэрэлтүүлгийн чадал 3.5 дахин буурсан.
3. Гэрэл сольсон хэсэгт 1 жилд 3,141.6 кВт эрчим хүчийг хэмнэнэ.
4. Эдийн засгийн хувьд 1 жилд 441,678 төгрөгийг хэмнэлт бий болно.






Ерөнхий боловсролын 17-р сургуулийн 1 давхрын 9 коридорт 14 ширхэг гэрэлтүүлгийг суурилуулан, эрчим хүчний хэмнэлтийг тооцов

Төслийн үр дүн

1. Орчны гэрэлтүүлгийн хэмжээ 2.1-2.4 дахин нэмэгдсэн.
2. Гэрэлтүүлгийн чадал 2.3 дахин буурсан.
3. Гэрэл сольсон хэсэгт 1 жилд 889.6 кВт эрчим хүчний хэмнэлт гарна.
4. Эдийн засгийн хувьд 1 жилд 125,069 төгрөгийг хэмнэнэ.

## ҮСГЭН ХАЯГ


Булган аймаг дахь "Хөдөлмөр халамж үйлчилгээний газар" -ын гэрэлтдэг үсгэн хаяг логог хийж суурилуулав.



"ЭРДМИЙН САН СУРГУУЛЬ" –ийн гэрэлтдэг үсгэн хаяг хийж гүйцэтгэв.



Ерөнхий боловсролын 4-р сургуульд Монгол ахуйг бэлгэдсэн үзүүлэнд “Өлзий хээ” гэрэлтдэг таазны гэрэлтүүлгийн хийж суурилуулав.



”Цонх хаалга, шилэн пасад” гэрэлтдэг үсгэн хаягийг хийж гүйцэтгэв.



”Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ”-н Зураг төслийн хүрээлэнгийн гадна үсгэн хаягийг зураг төслийн дагуу хийж гүйцэтгэв.



Эрдэнэт Мах маркет ХХКийн гэрэлтдэг үсгэн хаягийг Орхон молл ХҮТөв, болон компанийн байранд суурилуулав.



”Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ”-н  
Эрдэнэт сувилал,  
клиникийн гэрэлтдэг  
үсгийн хаягийг хийж  
гүйцэтгэн хүлээлгэн өгөв.




Орхон аймгийн ”LPG Lotus  
salon”-ийн гэрэлтдэг үсгэн  
хаягийг суурилуулав.



Орхон аймгийн цэцэрлэгт  
хүрээлэнгийн үсгэн хаягийг  
суурилуулав.



”Байгаль орчин, аялал  
жуулчлалын газар”-н  
мэдээллийн самбарыг хийж  
гүйцэтгэв.




## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД

Орхон аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуусыг хөгжүүлэх “Найдвар төв”-ийн 20 жилийн ойд зориулан Light box, мэдээллийн самбарыг хийж суурилуулав.



## ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛСЭН ШИНЭ АРГА БАРИЛ

Бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагын дотоод үйл ажиллагааг процессжуулан ажиллаж эхлээд байна.



Эрчим хүчний зохицуулах хорооны 352 тоот тушаалаар 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдрөөс “Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага” болж магадлан итгэмжлэгдлээ.





## ГЭРЭЛТҮҮЛГИЙН ГОСТ СТАНДАРТУУДЫГ СУНГАВ.

Гадаадын стандарт бүртгүүлэн хэрэглэх журмын дагуу 2020 оны 4 сараас ГОСТ стандартуудыг үйлдвэрлэлдээ нэвтрүүлсэн билээ. ГОСТ стандартын хүчин төгөлдөр байх хугацааг нэг жилээр сунгалаа.



## ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААГ СУНГАВ.

Эрчим хүчний яамны 0.4-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар сунгаж баталгаажууллаа.



## ОЛОН НИЙТЭД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА



### ЦАХИМ ҮЗЭСГЭЛЭН

ЖДҮ газраас зохион байгуулагдсан "ЭХ ОРОНЧ ХУДАЛДАН АВАЛТ ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ 2021" ONLINE EXPO цахим үзэсгэлэнд Анд-Энерги ХК-ийн цахим BOOTH-ыг үүсгэн 2021.04.01-нээс 05.01-н хүртэлх хугацаанд амжилттай оролцсон.



Ард аппликейшн нь Улаанбаатар Үнэт Цаасны Биржийн арилжааны системтэй холбогдсоноор иргэд гар утсаараа хандан Анд-Энерги ХК-ийн хувьцааг арилжих боломжтой болсон.



### "Эрдэнэт хот 45" 450 ИНЖЕНЕРИЙН ЗӨВӨЛГӨӨН

Эрдэнэт хотын 45 жилийн ойд зориулан зохион байгуулсан Орхон аймгийн инженерүүдийн зөвлөгөөнд оролцон, олон нийтийг хамарсан үзэсгэлэнд амжилттай оролцсон.



## ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

Орхон аймгийн  
"Шилдэг татвар төлөгч  
байгууллага"



Орхон аймгийн  
"Хэрэглэгчдийн  
найдвартай түнш  
байгууллага"



Орхон аймгийн БаянӨндөр сумын  
ИТХ-аас зохион байгуулсан ажлын  
байрны гадна тохижилт, өнгө  
үзэмжийг сайжруулах зорилготой  
"ӨНГӨЛӨГ ЭРДЭНЭТ ХОТ" аянд  
амжилттай оролцов.



## САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	ХЭМЖИХ НЭГЖ	2018	2019	2020	2021
Гэрлийн жижиглэнгийн борлуулалт	сая.төг	30.8	54.1	67.2	127.8
Гэрлийн бөөний борлуулалт		884	869.4	859.6	839.1
Цахилгаан тоног төхөөрөмж худалдаа				535.8	512.6
Цахилгаан тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт , Автоматжуулалтын ажил			456.5	408.9	325.8
Гэрэлтүүлгийн угсралт суурилуулалт				244.7	77.9
Анд-Маркет (хүнс, кофе шоп)				89.6	147.6
<b>Нийт борлуулалтын орлого</b>			<b>914.8</b>	<b>1,380.0</b>	<b>2,205.8</b>
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	сая.төг	597.3	880.2	1313	1266.5
Үйл ажиллагааны зардал		280.54	377.6	893.4	765
Цэвэр ашиг		32.4	22.1	24.5	13.8
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТ</b>					
Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо	ширхэг	34,472	25,699	25,731	21,914
Борлуулсан бүтээгдэхүүний тоо (үйлдвэрлэн)		31,129	22,448	37,243	21,690
Үйлдвэрлэлийн хүчин чадал		150-300	300-500	500-800	500-800
Ажил			11	8	17
Цахилгаан тоног төхөөрөмж нийлүүлэлт				3	2

## САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




**САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

**Борлуулалтын орлого /сая.төг/**



**Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо**




**Түүхий эдийн татан авалт /сая.төг/**




## САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Цэвэр ашиг /сая. төг/



## ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР ХУРААМЖ





## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН



**МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК**

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг  
16-р хороо, Амарсанавгийн гудамж, 12-1  
Колорадо бизнес төв, 1 давхар, 101 тоот  
Утас: 7013-1044. И-мэйл: info@magicgroup.mn  
Вэб хуудас: www.magicgroup.mn

2022.02.17      дугаар 21-118/03/17  
тандаг \_\_\_\_\_-ны дугаар \_\_\_\_\_-т

**АНД-ЭНЕРГИ ХК**–ийн  
хувьцаа эзэмшигчид

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

#### Дүгнэлт

Бид АНД-ЭНЕРГИ ХК ("Компани" гэх)-ийн 2021 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн томсоохон бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Компанийн 2021 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу үнэн зөв толилуулж байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЭЗОУСЗ)- өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЭЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

#### Тасралтгүй байдалтай холбоотой материаллаг тодорхойгүй байдал

Тасралтгүй үйл ажиллагааны зарчимтай холбоотой материаллаг тодорхой бус байдал бидэнд ажиглагдаагүй.

#### Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудал нь тайлант жилийн санхүүгийн тайланд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц зүйлс юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

#### Аудитын гол асуудлууд

##### Татварын тооцооллын үнэн, зөв байдал

Компанийн татварын өр төлбөрийн тооцоололт болон татварын хууль тогтоомжийн хэрэгжүүлэлт нь үнэлэмж шаарддаг учраас бид татварын тооцооллын үнэн, зөв байдлыг аудитын гол асуудал гэж үзсэн.

#### Бидний гүйцэтгэсэн аудитын горим

Татварын тооцооллын үнэн зөв, зохистой байдлыг үнэлэхтэй холбоотой бидний гүйцэтгэсэн горимууд:

- Татварын тооцоолол ба түүнтэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлого болон татварын талаарх удирдлагын байр суурь, үнэлгээг судлах, ойлгох;



АНД-ЭНЕРГИ ХК-ийн 2021 оны 12 сарын 31-ний өдрөөрх 21-48/03/22 тоот  
Хараат бус аудиторын тайлангийн (үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд	Бидний гүйцэтгэсэн аудитын горим
<p><b>Татварын тооцооллын үнэн, зөв байдал (үргэлжлэл)</b></p> <p>Монгол улсын татварын бодлого 2020 онд шинэчлэл хийн гол татварын багц хуулиудаа хэрэгжүүлж эхэлсэн. Үүний үр дүнд бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хууль журмууд ч мөн өөрчлөгдсөөр байна.</p> <p>Өөр өөр эрх бүхий байгууллагууд татварын хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж төлбөр торгууль тавих хуулиар тогтоосон эрхтэй байдаг. Компани татварын хууль тогтоомжийн ойлголт дээрээ үндэслэн бүх татваруудыг үнэн зөв тодорхойлсон гэж итгэж байгаа боловч дээр дурдсан хүчин зүйлүүдээс үндэслэн Компанид татварын эрсдэл байсаар байна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Татварын хууль, журам болон практикийн туршлагатай өөрсдийн татварын мэргэжилтнүүд болон Компани ба эрх бүхий татварын албадууд хоорондын харилцааг ашиглан санхүүгийн тайланд бүртгэгдсэн татварын өр төлбөрүүд нь зохистой эсэх, эсвэл татварын өр төлбөрийг бүртгээгүй үндэслэл шалтгааныг үнэлэх;</li> <li>- Санхүүгийн тайланд бүртгэгдсэн татварын өр төлбөр болон тодруулга нь хангалттай эсэх, уг өр төлбөр нь татварын хуулийн сүүлийн өөрчлөлтүүдийн дагуу тооцоологдсон эсэх, боломжит татварын торгууль болон хүүг агуулсан эсэхийг үнэлэх.</li> </ul>

**Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага**

Удирдлага нь СТОУС-уудын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр аргагүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах Компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

**Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үзнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээсэн үүрэг хариуцлагын тодорхойлолтыг Мэжик Консалтинг Аудит ХХК-ийн <http://www.magicgroup.mn/mn/uureg> вэб сайтад байршуулсан. Уг тодорхойлолт нь аудиторын тайлангийн нэг хэсэг юм.

АНД-ЭНЕРГИ ХК-ийн 2021 оны 12 сарын 31-ний өдрөөрх 21-46/03/77 тоот  
Хараат бус аудиторын тайлангийн (үргэлжлэл)

### Бусад асуудал

АНД-ЭНЕРГИ ХК-ийн 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлангуудад МОНГОЛИАН БИЗНЕС РЕЙТИНГ АУДИТ ХХК аудит хийсэн бөгөөд Эерэг дүгнэлт илэрхийлсэн байна.

### Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль" -ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох АНД-ЭНЕРГИ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



С.Мөнхбаяр  
Мэргэшсэн нягтлан бодогч, Партнер  
Мэжик Консалтинг Аудит ХХК

Улаанбаатар хот, Монгол Улс  
2022 оны 02 дүгээр сарын 17



## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

**АНД-ЭНЕРГИ ХК  
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН  
2021 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН**

	Тодруулга	2021 МЯН.ТОГ	2020 МЯН.ТОГ
<b>ХӨРӨНГӨ</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	4	13,288.5	25,659.0
Дансны авлага	5	299,802.7	197,477.2
Татвар, НДШ-ийн авлага	6	488.3	11,961.9
Бусад авлага	7	2,481.5	32,655.4
Бараа материал	8	349,216.8	619,299.3
Урьдчилж төлсөн төлбөр	9	214,732.7	
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>880,010.5</b>	<b>887,052.8</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө	10	1,667,908.7	1,769,503.0
Биет бус хөрөнгө	11	67,220.3	62,988.0
Биологийн хөрөнгө	12	6,500.0	
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		<b>1,741,629.0</b>	<b>1,832,491.0</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>2,621,639.5</b>	<b>2,719,543.8</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>			
Дансны өглөг	13	24,070.1	17,552.8
Татварын өглөг	14	19,185.4	46,084.5
НДШ-ийн өглөг	15	26,249.5	16,640.9
Богино хугацаат зээл	17	51,247.5	489,424.9
Хүүний өглөг	17	434.0	
Урьдчилж олсон орлого	16	22,486.5	6,985.0
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>143,673.0</b>	<b>579,688.1</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>			
Урт хугацаат зээл	17	406,214.0	47,450.5
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>406,214.0</b>	<b>47,450.5</b>
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>		<b>549,887.0</b>	<b>627,138.6</b>
<b>Өөрийн хөрөнгө</b>			
Хувьцаат капитал	18	78,070.8	78,070.8
Нэмж төлөгдсөн капитал	18	1,470,540.8	1,470,540.8
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	19	264,224.4	264,224.4
Хуримтлагдсан ашиг	20	258,916.5	279,569.2
<b>Нийт цэвэр хөрөнгийн дүн</b>		<b>2,071,752.5</b>	<b>2,092,405.2</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>2,621,639.5</b>	<b>2,719,543.8</b>

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**АНД-ЭНЕРГИ ХК  
 ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН  
 2021 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН**

	Тодруулга	2021 мян.төг	2020 мян.төг
Борлуулалтын орлого /цэвэр/	21	2,030,853.7	2,205,820.7
Борлуулалтын өртөг	22	1,266,555.7	1,312,416.5
<b>Нийт ашиг</b>		<b>764,298.0</b>	<b>893,404.2</b>
Хүүний орлого			310.9
Бусад орлого	23	16,709.5	699.8
Борлуулалт, маркетингийн зардал	24	-121,180.3	-118,221.2
Ерөнхий удирдлагын зардал	25	-541,032.8	-620,070.5
Санхүүгийн зардал	26	-78,359.3	-99,372.7
Бусад зардал	27	-24,813.0	-31,697.0
Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз/		0.7	3.9
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз/гарз/		-198.6	
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>		<b>15,424.2</b>	<b>25,057.6</b>
Орлогын татварын зардал		-1,542.4	-502.4
<b>Нийт дэлгэрэнгүй орлогыг илэрхийлэх тайлант жилийн ашиг</b>		<b>13,881.8</b>	<b>24,555.2</b>

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**АНД-ЭНЕРГИ ХК  
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН  
2021 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН**

Үзүүлэлт (мян.төг)	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2020-01-01-ний үлдэгдэл</b>	<b>78,070.8</b>	<b>1,470,540.8</b>	<b>72,573.7</b>	<b>364,587.2</b>	<b>1,985,772.5</b>
НББ-ийн өөрчлөлт, алдааны залруулга				-15,888.5	15,888.5
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>78,070.8</b>	<b>1,470,540.8</b>	<b>72,573.7</b>	<b>348,698.7</b>	<b>1,969,884.0</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	24,555.2	24,555.2
Зарласан ногдол ашиг	-	-	-	-93,684.7	-93,684.7
Дахин үнэлгээний нэмэгдэл			191,650.7	-	191,650.7
<b>2020-12-31-ний үлдэгдэл</b>	<b>78,070.8</b>	<b>1,470,540.8</b>	<b>264,224.4</b>	<b>279,569.2</b>	<b>2,092,405.2</b>
НББ-ийн өөрчлөлт, алдааны залруулга				-34,534.5	-34,534.5
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>78,070.8</b>	<b>1,470,540.8</b>	<b>264,224.4</b>	<b>245,034.7</b>	<b>2,057,870.7</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				13,881.8	13,881.8
Зарласан ногдол ашиг					
Дахин үнэлгээний нэмэгдэл					
<b>2021-12-31-ний үлдэгдэл</b>	<b>78,070.8</b>	<b>1,470,540.8</b>	<b>264,224.4</b>	<b>258,916.5</b>	<b>2,071,752.5</b>

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



**АНД-ЭНЕРГИ ХК  
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
2021 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН**

	2021 МЯН.ТӨГ	2020 МЯН.ТӨГ
<b>1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>2,189,615.9</b>	<b>2,469,820.5</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлдсний орлого	1,609,701.4	2,113,942.7
Бусад мөнгөн орлого	579,914.5	355,877.8
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>2,051,512.3</b>	<b>2,432,051.3</b>
Ажиллагчдад төлсөн	247,777.1	333,806.8
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	82,122.1	58,726.3
Бараа материал худалдан авахад төлсөн	1,063,032.0	1,557,529.6
Ашиглалтын зардалд төлсөн	8,818.4	6,386.6
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	32,442.1	2,226.4
Хүүний төлбөрт төлсөн	77,925.2	99,372.7
Татварын байгууллагад төлсөн	210,782.0	192,480.7
Даатгалын төлбөрт төлсөн	1,256.9	-
Бусад мөнгөн зарлага	327,356.5	181,522.2
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>138,103.6</b>	<b>37,769.2</b>
<b>2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>7,000.0</b>	<b>310.9</b>
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	7,000.0	-
Бусдад олгосон зээл мөнгөн урь-ны буцаан төлөлт	-	310.9
Хүлээн авсан хүүгийн орлого	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>76,900.4</b>	<b>91,326.0</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	14,285.0	59,007.8
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,232.2	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	58,383.2	32,318.2
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-69,900.4</b>	<b>-91,015.1</b>
<b>3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>722,870.0</b>	<b>555,476.9</b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гар-аас хүлээн авсан	722,870.0	555,476.9
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>803,443.7</b>	<b>523,094.7</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	803,443.7	438,778.3
Төлсөн ногдол ашиг	-	84,316.4
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-80,573.7</b>	<b>32,382.2</b>
Валютын ханшийн зөрүү	-	-
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-12,370.5</b>	<b>-20,863.7</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>25,659.0</b>	<b>46,522.7</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>13,288.5</b>	<b>25,659.0</b>

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.




## Стратегийн 3 жилийн зураглал 2022-2025 он хүртэлх

Менежментийн процессууд	Стратегийн зураглал 3 жил	Стратегийн зорилтууд	Хэмжих нэгж	Хүрэх үр дүн
Санхүү	*Өөрийн хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх	Борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх	төгрөг	2,7 тэрбум
	*Орлогын урсгал нэмэгдүүлэх	Өртгийг тооцох системийн аргачлалтыг боловсруулж, хэмжигдэхүйц болгох	өртгийн бууралтын хувь	11,5
	*Өртөг тооцох системийг төгөлдөржүүлэх	Ашигт ажиллагааг нэмэгдүүлэх	хувь	10
Маркетинг	*Брендийн үнэ цэнийг нэмэгдүүлэх	Брендийн танигдалтыг нэмэгдүүлэх	Өрсөлдөөний хүч /хувь/	40
	*Хэрэглэгчтэй харилцаа тогтоох системийн сайжруулалт	Хэрэглэгчтэй харилцаа холбоо үүсгэх системийг сайжруулах	Үйлчлүүлэгчтэй тохиролцох чадвар /хувь/	50
		Зорилтод харилцагчийг тодорхойлж, зах зээлд эзлэх хувийг нэмэгдүүлэх	борлуулалтын орлого өсөлтийн хувь	24,7
Үйл ажиллагаа	*Үйлдвэрлэлийн менежментийн арга хэрэгслийг хэвшүүлэх	<b>Менежментийн хамгийн тохирсон аргачлалыг судлан нэвтрүүлэх</b>	<b>хэрэгжилтийн хувь</b>	<b>50</b>
	*Судалгаа хөгжлийн үйл ажиллагааг тогтмолжуулах	Бүтээгдэхүүн хөгжүүлэх	тоо	3-5
Хүний нөөц	*Эрдэм мэдлэгтэй, бүтээлч, хамтын хүчийг дээдлэгч хүний нөөцийг бий болгох	<b>Зорилтод хүний нөөцийг сонгох</b>	<b>ГГҮ хувь</b>	<b>90</b>
	*Зорилтод хүний нөөцийг бүрдүүлэх	Мэргэшүүлэх, хөгжүүлэх сургалт	стратегийн хэрэгжилтийн хувь	80
	*Зорилтод сургалт хөгжил	Ажилчдын сэтгэл ханамж	бүтээмжийн өсөлтийн хувь	90
	*Ойлгомжтой, ил тод, урам зориг бадраасан урамшууллын систем			

Үйл ажиллагааны төлөвлөгөө 2022 он


Алба	Өнөөгийн түвшинг тодорхойлох стратеги	Тогтвортой орлогыг бүрдүүлэх, гүйцэтгэлийн үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлох стратеги	Ашигт ажиллагааг нэмэгдүүлэх стратеги
СТА	Өртөг тооцох аргачлалыг боловсруулан, бодит гүйцэтгэлд хэмжилт хийх	Өртөг тооцох аргачлалаа сайжруулж гүйцэтгэлийн хэмжүүрийн хүрэх түвшинг тодорхойлж, үр дүнг хянах	Боловсруулсан аргачлалаа санхүүгийн программд оруулан бүртгэх (автоматжуулах)
	Орлогын бүтцийг боловсронгуй болгох	Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн бодлогыг тодорхойлж, удирдан үр дүнд хэмжилт хийж, үр дүнг хянах	НББ-н бодлогын баримт бичигт тусган баталгаажуулж, мөрдөн ажиллах
	Орлого нэг бүрт эргэцийн өнөөгийн байдлыг тодорхойлох	Эргэцэд нөлөөлөх үзүүлэлтүүдийг сайжруулалт хийж, үр дүнг хянах	
МБА	Харилцагчийн дата үүсгэн, зорилтод сегментийг тодорхойлох	Зорилтод сегментийг нэмэгдүүлж, эргэх холбоог сайжруулж, үр дүнг хянах	Зорилтод сегмент бүрт тохирох 4P тодорхойлох
	Брендийн хүчийг үнэлүүлж, зах зээлийн багтаамжийг тодорхойлох	Брендийн мөн чанарыг бүтээгдэхүүнд шингээх сайжруулалт, идэвхжүүлэлт хийж, үр дүнг хянах	Зорилтод сегментэд брендийг хоногшуулах
СХбаҮА	Гэрэл үйлдвэрлэлийн процессийн схемийг боловсруулж, гүйцэтгэлийн үзүүлэлтийг хэмжих	Ажил үйлчилгээ, бүтээгдэхүүн үйлдвэрлэлд тохирсон үйлдвэрлэлийн аргачлалыг нэвтрүүлэн бүтээмжийг нэмэгдүүлэн, үр дүнг хянах	Чанарын удирдлагын тогтолцоо болон 5S хөдөлгөөн өрнүүлж чанар, бүтээмжийг нэмэгдүүлэх
	Сайжруулалт хийх шаардлагатай бүтээгдэхүүний жагсаалтыг гаргаж, шалтгааныг тодорхойлох	Бүтээгдэхүүн сайжруулах шийдэл боловсруулж, үйлдвэрлэлд нэвтрүүлж, үр дүнг хянах	Эрэлтэд нийцсэн шинэ бүтээгдэхүүний шийдэл боловсруулж үйлдвэрлэлд нэвтрүүлэх
Хүний нөөц	Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүдийг тодорхойлох	Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүдийн хэмжүүрийг тодорхойлж, урамшууллын системтэй уялдуулан, үр дүнг хянах	Зорилтоор нь удирдах


 Утас: 88351298, 77711010

 E-mail: [info.andenergy@gmail.com](mailto:info.andenergy@gmail.com)

 [www.andenergy.mn](http://www.andenergy.mn)

 And Energy

 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Уртын гол баг, Баян зам 3-4,6 тоот

 Борлуулах цэг:  
Эрдэнэт хот- Үйлдвэрийн байр, нэрийн дэлгүүр  
Улаанбаатар хот- Мишээл экспо барилгын их дэлгүүр

87-р павилон